



**ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2013 оны 12 сарын 13 өдөр

Дугаар А/228


Улаанбаатар хот

Журам батлах тухай

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3 дахь заалт, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын зөвлөлийн 2013 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Шийдвэр гүйцэтгэгчид мэргэшлийн зэрэг олгох, ур чадварын нэмэгдэл олгох журам”-ыг нэгдүгээр, “Шийдвэр гүйцэтгэгчийн мэргэшлийн зэргийн ялгах тэмдгийн загвар”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Шийдвэр гүйцэтгэх албадын дарга нарт, хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллахыг Шийдвэр гүйцэтгэх газар /хурандаа Д.Дамдинцэрэн/-т тус тус даалгасугай.
3. Шийдвэр гүйцэтгэгч нарын ур чадварын нэмэгдэлд зарцуулагдах мөнгөн хөрөнгийг зохих журмын дагуу гаргахыг Санхүү, үйлдвэр, хөрөнгө, оруулалтын газар /хурандаа М.Хуягбаатар/-т зөвшөөрсүгэй.

ДАРГА, ХУРАНДАА



Д.ЯДАМДОРЖ

1 дүгээр	Бодит биелэлт тухайн жилийн улсын дунджаас 20 хувиар дээгүүр байх	Тэнцсэн	Сахилгын шийтгэл сүүлийн 2 жил хүлээгээгүй
2 дугаар	Бодит биелэлт тухайн жилийн улсын дунджаас 15 хувиар дээгүүр байх	Тэнцсэн	Сахилгын шийтгэл сүүлийн 1 жил 6 сар хүлээгээгүй
3 дугаар	Бодит биелэлт тухайн жилийн улсын дунджаас 10 хувиар дээгүүр байх	Тэнцсэн	Сахилгын шийтгэл сүүлийн 1 жил хүлээгээгүй

3.2. Шийдвэр гүйцэтгэгчийн мэргэшлийн зэргийг Улсын ерөнхий гүйцэтгэгчийн санал болгосноор Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын тушаалаар олгоно.

3.3. Шийдвэр гүйцэтгэгчээс өөр бусад ажил, албан тушаалд томилогдон ажиллаж байгаад шийдвэр гүйцэтгэгчээр дахин томилогдоход урд хэрэглэж байсан мэргэшлийн зэргийг буцаан олгохгүй.

3.4. Мэргэшлийн зэрэг олгох шалгалтад шийдвэр гүйцэтгэгчээр 2-оос дээш жил ажилласны дараа орох эрхтэй.

3.5. Сахилгын шийтгэл хүлээсэн шийдвэр гүйцэтгэгчийн мэргэшлийн зэргийг 6 сараас 1 жилийн хугацаагаар бууруулна.

3.6. Шийдвэр гүйцэтгэгч нь сахилгын шийтгэл хүлээсэн, түүний ажлын үзүүлэлт нь өмнөх жилийн улсын дунджаас буурсан тохиолдолд мэргэшлийн зэргийг Шийдвэр гүйцэтгэх албаны даргын тушаалаар бууруулна.


3.7. Шийдвэр гүйцэтгэгч нь тухайн байгууллагаас чөлөөлөгдсөн, халагдсан тохиолдолд мэргэшлийн зэрэг нь хүчингүй болсонд тооцно.

3.8. Энэ журмын 3.6-д зааснаар мэргэшлийн зэргийг бууруулсан тохиолдолд энэ тухай Улсын ерөнхий гүйцэтгэгчид мэдэгдэх бөгөөд бусад тохиолдолд шийдвэр гүйцэтгэгчийн мэргэшлийн зэргийг бууруулахгүй.

Дөрөв. Шийдвэр гүйцэтгэгчид ур чадварын нэмэгдэл олгох

4.1. Шийдвэр гүйцэтгэгчийн ур чадварын нэмэгдлийг түүний үндсэн цалингийн дараах хувиар тооцон олгоно.

Мэргэшлийн зэрэг	1 дүгээр зэрэг	2 дугаар зэрэг	3 дугаар зэрэг
Нэмэгдлийн хувь	30	25	20



Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2023 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн АБ/2 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

Шийдвэр гүйцэтгэгчид мэргэшлийн зэрэг олгох, ур чадварын нэмэгдэл олгох журам

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Шийдвэр гүйцэтгэгчид мэргэшлийн зэрэг, ур чадварын нэмэгдэл олгох, шийдвэр гүйцэтгэгчийн мэргэшлийн зэргийг бууруулах, хүчингүй болгох, мэргэшлийн зэргийг тогтооход энэхүү журмыг баримтлана.

1.2. Шийдвэр гүйцэтгэгчид мэргэшлийн 1, 2, 3 дугаар зэргийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын тушаалаар олгоно.

1.3. Шийдвэр гүйцэтгэгчийн мэргэшлийн зэргийг олгохдоо шийдвэр гүйцэтгэгчээр ажилласан хугацаа, ажил хэргийн ур чадвар буюу гүйцэтгэх хуудасны бодит биелэлт, ёс зүйн хэм хэмжээг сахиж буй байдлыг харгалзан мэргэшлийн зэрэг олгох шалгалт авна.

1.4. Мэргэшлийн зэрэг олгосон шийдвэр гүйцэтгэгчид энэ журамд заасан ур чадварын нэмэгдлийг олгоно.

1.5. Энэхүү журамд ахлах гүйцэтгэгч, шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хариуцсан мэргэжилтэн хамаарахгүй.

Хоёр. Мэргэшлийн зэрэг олгох шалгалт

2.1. Улсын ерөнхий гүйцэтгэгчээр ахлуулсан 5 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг мэргэшлийн зэргийн шалгалтыг жилд 1 удаа зохион байгуулна.

2.2. Шалгалтыг зохион байгуулах хугацаа, ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Улсын ерөнхий гүйцэтгэгчийн санал болгосноор Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын тушаалаар батална.

2.3. Шалгалтыг 100 асуулт бүхий сорил бөглүүлж, бичгээр авах бөгөөд мэргэшлийн зэрэг тус бүрийн сорилго адилгүй байхаар бэлтгэж зохион байгуулна.

2.4. Сорилыг 70 хувиас доошгүй бөглөсөн шийдвэр гүйцэтгэгч тухайн мэргэшлийн зэргийн шалгалтад тэнцэнэ.




Гурав. Шийдвэр гүйцэтгэгчид мэргэшлийн зэрэг олгох, бууруулах, хүчингүй болгох

3.1. Шийдвэр гүйцэтгэгчийн мэргэшлийн зэргийг тогтоох шалгуур, үзүүлэлт:

Мэргэшлийн зэрэг	Ажлын ур чадвар	Мэргэшлийн зэргийн шалгалт өгсөн байдал	Ёс зүйн хэм хэмжээг сахиж буй байдал
------------------	-----------------	---	--------------------------------------

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2013 оны 24 дугаар сарын 13-ны өдрийн 411/2 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭГЧИЙН МЭРГЭШЛИЙН ЗЭРГИЙН ЯЛГАХ ТЭМДГИЙН ЗАГВАР



4.2. Ур чадварын нэмэгдлийг мэргэшлийн зэрэг олгосон өдрөөс эхлэн дараа жилийн мэргэшлийн зэрэг олгох шалгалтад хамрагдах хүртэл сар бүр олгоно.

4.3. Шийдвэр гүйцэтгэгч сахилгын шийтгэл хүлээж, мэргэшлийн зэрэг буурсан тохиолдолд түүнд сахилгын шийтгэл хүлээсэн өдрөөс эхлэн ур чадварын нэмэгдлийг буурсан мэргэшлийн зэргээр олгоно.

Тав. Шийдвэр гүйцэтгэгчийн мэргэшлийн зэргийн ялгах тэмдэг

5.1. Шийдвэр гүйцэтгэгчийн дүрэмт хувцасны баруун гар талын ханцуйн дээр энэ журмын 2 дугаар хавсралтаар батлагдсан зураас бүхий ялгах тэмдгийг хадна.

5.2. Шийдвэр гүйцэтгэгчийн мэргэшлийн зэргийн ялгах тэмдэг нь Шийдвэр гүйцэтгэх албаны ялгах тэмдэгийн дагуу ханцуйн үзүүрээс 6 см-ийн зайтай байна.

5.3. Шийдвэр гүйцэтгэгчийн ялгах тэмдэгийн дэвсгэр нь хөх, зураас нь шар өнгөтэй байна.

5.4. Шийдвэр гүйцэтгэгчийн мэргэшлийн зэргийн ялгах тэмдэгийн зураас нь:

- Нэгдүгээр зэрэг - 3 зураас
- Хоёрдугаар зэрэг - 2 зураас
- Гуравдугаар зэрэг - 1 зураас

Зургаа. Бусад

6.1. Энэ журмыг зөрчсөн албан тушаалтан, албан хаагчид холбогдох хууль тогтоомжид заасан сахилгын шийтгэл оногдуулна.

--- оОо ---